

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ
(Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам)

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбө-рийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт		Хэрэгжилт	Хувь
						Суурь түвшин /2023 он/	Зорилт от түвшин /2025 он/	Санхүү-жилт, /сая.төг./	Санхүү-жилтийн эх үүсвэ-рийн ангилал		
МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: ХҮНИЙ ХӨГЖИЛ БҮЛГИЙН ХҮРЭЭНД:											
	ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.										
3.3.Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	3.3.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаал-лын үйлчилгээ ний хүртээмж, чанарыг сайжруул-на.	МУХТЖҮЧ -2.3.1, ЗГҮАХ-2.1.2.6	3.3.1.1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилтийн төслийг хэрэгжүүлэх	Төслийн хэрэг-жилт	Хувь	-	100	20,000.0	Улсын төсөв	Эрх зүйн орчин: Мэдээллийн нууцлалыг хангах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох аргачлалыг ГБХНХ-ын сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар батлууллаа. Техникийн дэд бүтэц: Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр их өгөгдлийн тоног төхөөрөмжийг худалдан авч, Үндэсний дата төв (ҮДТ)-д бүрэн суурилуулж, техникийн орчныг бэлэн болгов. Систем хөгжүүлэлт: Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласны үр дүнд харьяа агентлагуудын 4 мэдээллийн санг нэгтгэсэн "Салбарын их өгөгдлийн сан"-г үүсгэлээ. Үр дүн (Дашбоард): Бодлогын дүн шинжилгээ хийх зориулалттай дараах 5 төрлийн дашбоард хөгжүүлж, ашиглахад бэлэн болоод байна. Үүнд: Яам 360 KPI	100

									- Нийгмийн даатгал (Sigo 360) - Нийгмийн халамж 360 - Хөдөлмөр 360 - Өрхийн мэдээллийн сан 360 Дээрх нэгдсэн дашбоардуудыг ашиглан нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт, хүн амын чиглэлээр бодлогын дүн шинжилгээ хийх нөхцөл бүрдсэн. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн (ипотекийн санхүүжилт) нөхцлийг зорилтот бүлэгт тодорхойлох дүн шинжилгээг энэхүү их өгөгдлийн мэдээлэл дээр үндэслэн ашиглаж байна. <u>Төсвийн гүйцэтгэл: 15.3 тэрбум төгрөг /гэрээ байгуулсан дүн/</u>		
		МУХТЖҮЧ -2.3.2, ЗГҮАХ- 2.1.1.4, 2.1.1.5	3.3.1.2. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байгуулах, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	Шинээр ашиглалтад орох барилга	Тоо	-	2	2,947.5	Улсын төсөв	Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг ажиллуулахад ямар нэгэн барилга байшин шинээр барихгүй бөгөөд орон нутагт байгаа барилга, байгууламждаа түшиглэн ажиллуулах юм. 2025 онд Хэнтий аймгийн Батноров, Бор-Өндөр сум болон Баянзүрх дүүргийн 17, 12, 26, 21, 25 дугаар хороонд Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг загвар болгон байгуулан ажиллуулж эхлээд байна. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байгуулахад тухайн сумаас дэмжлэг үзүүлж, төв байгуулах байрыг шийдвэрлэж өгсөн бөгөөд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газраас 24 мкв байрыг засварлан хүлээлгэж өгсөн. Төвийн байрыг дотоод нөөц бололцоогоо ашиглаж тохижуулан одоо үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Батноров сумын Засаг даргын Тамгын газраас төв байгуулах байраар хангаж, байрны засварын ажлыг хийсэн. Сэлэнгэ аймагт Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний барилга байгууламж бэлэн болсон бөгөөд санхүүжилт шийдвэрлээгүйгээс төвийн үйл ажиллагааг 2026 оноос эхлүүлэхээр ажиллаж байна. Иймээс Гэр бүл,	100

									хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/3405 тоот албан бичгээр 2026 оны орон нутгийн төсөвт цогц төвийг ажиллуулах зардлыг тусгуулах чиглэлийг бүх шатны Засаг дарга нарт болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт хүргүүлээд байна. Улсын нэгдсэн төсөвт энэ үйл ажиллагаанд тусгайлан батлагдсан төсөв тусгагдаагүй. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн барилга байгууламж, хүний нөөцийг түшиглэн гэр бүлийн үйлчилгээний төв байгуулж, тухайн орон нутгыхаа хүн амын хөгжил, оролцоог дээшлүүлэх заавар боловсруулны дагуу эхний ээлжид төсвийн хүндрэлтэй байгаа ч сум. хороонд өөрсдийн нөөцөд тулгуурлан төвийг нээн ажиллуулж байна. Нэмэлт тайлбар: Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/63 тушаалаар Гэр бүлийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн 2025 оны зардлаас санхүүжүүлэх арга хэмжээг баталсан бөгөөд энэ арга хэмжээнд <u>70,0 сая төгрөг баталсан. Гэвч төсвийн тодотголоор хасагдсан.</u> 2025 онд Гэр бүлийн хөгжил, хамгаалал хөтөлбөр, 80103-Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ, 210901-Бараа үйлчилгээний бусад зардал 20.0 саяаас 12,040,000 шилжсэн 7,960,000 үлдсэн дутуу байгаа энэ онд гүйлгээ хийгдэхээр хүлээгдэж байгаа. Өөр зардал гараагүй болно. ГБХНХЯ-наас хүргүүлсэн төлөвлөгөөний саналд энэ арга хэмжээн дээр ямар нэг төсөв тусгаагүй. Батлагдсан төлөвлөгөөнд туссан 2,947.5 төгрөг нь энэ арга хэмжээний зардал биш бөгөөд Улсын төсвийн хөрөнгөөр Ховд аймагт 2024-2026 онд баригдах гэр бүлийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх дүн байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

				Хүүхэд, гэр бүлийн салбарын нийгмийн ажилтны тоо	Тоо	330	966	0	Улсын төсөв	МУ-ын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.7-д "Сум, хороо бүрд нийгмийн ажилтан ажиллууллуулна" гэсэн зорилт дэвшүүлсэн. 2024 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, уг хуулийн 58 дугаар зүйлд 2025 оны 01-р сараас эхлэн сум, хороодод хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллахаар заасан. Дээрх үндэслэлээр Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоол гарч, тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал", 2 дугаар хавсралтаар "Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо"-г нийслэлд 268, орон нутагт 565, нийт 833 албан хаагч ажиллахаар тогтоосон. 2025 оны 12-р сарын 05-ны өдрийн байдлаар 773 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг сонгон шалгаруулж, ажилд томилон, мэргэжлийн удирдлагаар ханган, ажиллаж байна. Төсвийн хэмнэлтийн тухай хууль блоон ТҮ-ний албан тушаалтны тоог нэмэгдүүлэхгүй байх, ТҮ алыг 9-10 хувь цомхотгож, зардал хэмнэх ЗГ-ын чиглэлийн дагуу орон тоо нэмээгүй болно.	90
		МУХТЖҮЧ -3.1.1, ЗГҮАХ- 2.1.1.18	3.3.1.3. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлэх	Шинээр ашиглалтад орох барилга	Тоо	-	3	6,419.8	Улсын төсөв	Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталсан. Уг хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ахмад настанд цогц үнэлгээ хийж 1-3 түвшинд үнэлэн, шаардлагатай үйлчилгээг тодорхойлон дараах төрлийн хувилбарт үйлчилгээ үзүүлэхээр хуульчилсан. Үүнд: 1. Гэрээр асрах үйлчилгээ. 2. Өдрөөр асрах үйлчилгээ. 3. Асралт гэр бүлээр асрах үйлчилгээ. 4. Түр хугацаагаар асрах үйлчилгээ.	70

										5. Урт хугацаагаар асрах үйлчилгээ. 6. Байнга асрах үйлчилгээ. 7. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” А/76, А/515 дугаартай тушаалын хавсралтаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” А/75, А/514 дугаартай тушаалын хавсралтаар “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ууд батлагдсан. Мөн Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ батлах тухай” А51/А37 дугаар хамтарсан тушаалаар хувилбарт үйлчилгээ үзүүлэх тариф батлагдсан. Батлагдсан хууль, журмын хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 7,437 ахмад настан идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг 29 байгууллага, 19 байгууллага 794 ахмад настанд гэрээр асрах болон өдрөөр асрах үйлчилгээг үзүүлсэн бол 58 ахмад настанд 1 байгууллага түр болон урт хугацааны асрах үйлчилгээг үзүүлсэн. Түүнчлэн ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний барилга байгууламжийг шинээр барих хүрээнд Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн барилга Хөвсгөл	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрт байршилтай тэнхлэгээрээ 48м*15м хэмжээтэй, А блок-2 давхар, Б,В блок-1давхар 2,142 квм талбай бүхий 2 давхар шинэ барилгын ажлын гүйцэтгэл 2025 онд ажлын явц 58 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилгын 2025 оны төсөвт өртөг нийт 4.810.300.000 төгрөг батлагдсан бөгөөд <u>2025 олгосон санхүүжилтийн хэмжээ 1.580.300.000 төгрөг байна.</u>	
	3.3.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана.	МУХТЖҮЧ-2.3.4, ЗГҮАХ-2.1.1.26	3.3.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулах	Хөгжлийн төв	Тоо	0	3	8,585.3	Улсын төсөв	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Баянзүрх дүүрэг, Завхан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, 2026 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулахаар 2025 онд Төслийн удирдах хорооны хурлаар барилгын ажлын гүйцэтгэлд 30 хувийн санхүүжилт болох нийт 5,6 тэрбум батлагдсан ч Сангийн яамнаас 2025 оны санхүүжилтийн дээд хязгаарыг тогтоож, тус 2 барилгын ажилд төсөв тусгагдаагүй болно. Дээрх 2 төвийн барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулсан. Үүнд: 1. Завхан аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Морин сувд” ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 02/176 тоот гэрээг байгуулсан. 2. Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/209 тоот тушаалаар батлуулж, тендерийг зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн	100

									“Хөххайрхан трейд” ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 02/156 тоот гэрээ байгуулсан. Мөн Өмнөговь аймаг дахь хөгжлийн төвийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд ажиллуулахаар Засгийн газрын холбогдох тогтоолыг батлуулсан. Архангай аймаг дахь төвийн барилгыг 2025 оны 12 дугаар сард багтаан хүлээн авахаар Улсын комисст хүсэлтээ уламжилсан.	
		МУХТЖҮЧ -2.3.4, ЗГҮАХ- 2.1.1.29	3.3.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах	Арга хэмжээн ий хэрэгжил т	Хувь	0	100	10,642.2 Гадаад зээл	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн удирдах хорооны хурлаар 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 28 арга хэмжээтэйгээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, 12,6 тэрбум төгрөгийн төсвийг баталсан бөгөөд Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн дээд хязгаараар 2,9 тэрбум батлагдаж, нэмэлтээр санхүүжилт авч, <u>төсвийн зарцуулалт 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4,4 тэрбум буюу 152,2 хувийн гүйцэтгэлтэй байна.</u> Төслийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 28 арга хэмжээнээс төсвийн хязгаарлалтай холбогдуулан Сангийн яамнаас ирүүлсэн санхүүжилтээс шалтгаалан 5 арга хэмжээг хойшлуулсан. Нийт хэрэгжилт тооцох 23 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 18, 95 хувийн гүйцэтгэлтэй 4, 80 хувийн гүйцэтгэлтэй 2, хэрэгжилт удаашралтай 3 арга хэмжээ байна. Хэрэгжилт удаашралтай 3 арга хэмжээний тухайд Завхан аймаг, Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нийт 3 удаа зарлаж, тус тендерт хамгийн сайн тендерээр шалгарсан “Морин сувд” ХХК-	90
								529.6 Гадаад тусламж		

										тай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 02/176 гэрээг, Хөх хайрхан трейд ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 02/156 тоот гэрээг тус тус байгуулсан.	
3.4.Нийгмийн баталгааг сайжруулна.	3.4.1.Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	МУХТЖҮЧ -3.1.5, ЗГҮАХ- 2.1.1.22	3.4.1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх	Тэтгэврийн нэмэгдлийн хувь	Хувь	23.7	6	304,726.7	Улсын төсөв	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны бүх тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлэн олгосон. Энэхүү арга хэмжээний хүрээнд хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 572.4 мянган төгрөг, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянган төгрөг, дундаж тэтгэврийн хэмжээ 859.5 мянган төгрөгт хүрсэн. Нийт зарцуулсан төсөв 304,726.7 сая төгрөг.	100
	3.4.2. Төрийн албаны хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.	МУХТЖҮЧ -2.6.5, ЗГҮАХ- 2.1.2.7	3.4.2.1. Төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх	Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл	Хувь	14.2	6	424,427.2	Улсын төсөв	Монгол Улсын 2025 оны улсын төсөвт тусгасны дагуу Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ 954.0 мянган төгрөг болсон. Түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын нэмэлт хэлэлцээрийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс боловсролын салбарын албан хаагчдын үндсэн цалинг 50 хувиар, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалинг 30 хувиар, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар тус тус нэмэгдүүлэхээр тохиролцсон. Бусад салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. <u>2025 онд 424.4 тэрбум орчим төгрөг нэмж шаардагдахаар төсөвлөсөн.</u>	100

3.5.Зохис- той хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ	3.5.1. Ажиллах хүчний оролцоог нэмэгдүүл нэ.	МУХТЖҮЧ -2.6.1, ЗГҮАХ- 2.1.1.16, 2.1.2.11	3.5.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн барилга барих	Ашиглал тад орох барилга	Тоо	0	1	550.1	Улсын төсөв	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэлд тусгасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын эмнэлгийн шинэ барилгын ажил эхэлсэн ба 8 давхар, 4200 мкв талбай бүхий эмнэлгийн барилгын ажил дуусаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд хүлээлгэн өглөө. Тус барилга ашиглалтад орсноор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаа, Хөдөлмөрийн анагаах ухааны газрын үйл ажиллагаа нэгдэж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын үйл ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдэж байна. <u>Тус барилга нь 14.1 тэрбум төгрөгийн өртөгөөр баригдсан.</u>	100
		МУХТЖҮЧ -2.6.2, 2.6.3, 2.6.4, ЗГҮАХ- 2.1.1.30	3.5.1.2. Зорилтот бүлгийн иргэдийн хувиараа эрхлэх аж ахуй, гарааны бизнесийг дэмжих зорилгоор хүүгүй, барьцаагүй, эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг болон бусад шинэ арга	Хөдөл- мөр эрхлэл- тийг дэмжих хөтөл- бөрт хамраг- даж ажлын байртай болсон зорилтот бүлгийн иргэд	Хувь	0	52	40	Улсын төсөв	Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.12-т “бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” гэж 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг хэлнэ” гэж заасны дагуу холбогдох иргэн, аж ахуйн нэгжид жижиг зээлийг олгоно. Дээр дурдсан жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр	70

			дэмжлэгийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих							эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд <u>5,314 иргэн хамрагдаж, 4,529 иргэн ажлын байраар хангагдаж, 30,899,762,149 төгрөгийг, төсвийн гүйцэтгэл 77.5 хувьтай байна.</u> Үүнээс: • Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1689 иргэн хамрагдаж, 1,864 иргэн ажлын байраар хангагдаж, 15,009,000,000 төгрөгийг; • Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 854 иргэн хамрагдаж, 1,373 иргэн ажлын байраар хангагдаж, 6,836,875,960 төгрөгийг; • Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 633 иргэн сургалтад хамрагдаж хамрагдаж, 101 иргэн ажлын байраар хангагдаж, 827,213,400 төгрөгийг; • Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1094 иргэн хамрагдаж, 1,162 иргэн ажлын байраар хангагдаж, 7,586,500,000 төгрөгийг; • Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 28 иргэн хамрагдаж, 28 иргэн ажлын байраар хангагдаж, 225,060,000 төгрөгийг; • Түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1018 иргэн хамрагдаж, 414,112,789 төгрөгийг тус тус зарцуулсан байна.	
		МУХТЖҮЧ-2.3.4, ЗГҮАХ-2.1.1.19		Мян.хүн	Хувь	1.09	2.5	0	Улсын төсөв	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Түр ажлын	90

			3.5.1.3. Ахмад настны ажлын байрыг нэмэгдүүлэх						байраар хангах болон “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ”-г хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд: - Ахмад мэргэжилтний ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, эзэмшсэн мэдлэг, ажлын туршлагыг хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг сургалт, ментор, дадлагын хэлбэрээр үзүүлэх байдлаар зохион байгуулах, -Тухайн орон нутгийн ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Дээрх арга хэмжээнд 2025 онд нийт 1725 ахмад, 40 ахмадын холбоо, ТББ-ыг хамруулж, ХЭДС-аас 2.7 тэрбум төгрөгийг зарцуулна. Мөн Хувиараа хөдөлмөр эрхлэх ахмад настанд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг өмнөх жилүүдийнхээс нэмэгдүүлж, Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх ахмадуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажиллаж байсан ажил мэргэжлийн чиглэлийг заахгүйгээр сонгон шалгаруулж ажиллах боломжийг бүрдүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 1059 ахмад настан хамрагдаж, <u>996,039,000 төгрөгийг, Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээнд 29 ТББ 186 ахмад настан хамрагдаж 271,565,800 төгрөгийг, Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний чиг үүргийн ажилд 224 ахмад настан хамрагдаж, 299,694,800 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</u>	
--	--	--	---	--	--	--	--	--	--	--

		МУХТЖҮЧ -2.6.2, ЗГҮАХ- 2.1.1.27	3.5.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх	Мян.хүн	Хувь	1.43	2.0	15.700.0	Улсын төсөв	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Түр ажлын байраар хангах болон “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ”-г хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд 110 иргэн хамрагдаж, <u>1,223,764,000 төгрөгийг:</u> Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 827 иргэн хамрагдаж, 906 иргэн ажлын байраар хангагдаж, <u>6,194,400,000 төгрөгийг:</u> Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 1251 иргэн хамрагдаж, <u>125,374,524 төгрөгийг:</u> Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэгийн үйл ажиллагаанд 186 иргэн хамрагдаж, <u>282,768,525 төгрөгийг:</u> Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 28 иргэн хамрагдаж, 28 иргэн ажлын байраар хангагдаж, <u>163,988,000 төгрөгийг:</u> Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 68 байгууллага хамрагдаж, <u>1,660,693,252 төгрөг тус тус зарцуулсан байна.</u> Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/48 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	100
--	--	--	--	---------	------	------	-----	----------	----------------	--	-----

										жил” болгон зарласантай холбогдуулан 43 арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж байна.	
Нийт 11 арга хэмжээ (12 шалгуур үзүүлэлт). Үүнээс: 100%-7, 90%-2, 70%-2.											92.7